

МОНГОЛ УЛС ДАХЬ ХААНТ ОРОСЫН АШИГ СОНИРХОЛ (XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕ)

Г.Цэнджав¹

Энэхүү судалгааны өгүүлэлд монголчууд Чин гүрнээс салан тусгаарлах гэсэн тэмцэлдээ Хаант Орос улсаас тусламж эрсэн нь ямар учиртай болох, мөн түүнд Оросын зүгээс хэрхэн хандсан асуудлыг тодруулахын зэрэгцээ Оросын зүгээс Монголын тусгаар тогтнолын хэрэгт дэмжлэг үзүүлсний цаад учир шалтгаан юунд оршиж байсан тухай өгүүлэх болно.

Тэртээ 1691 оноос хойш харь Чин гүрний зах хязгаар муж болон бөглүү түгжигдмэл байдалтай оршсоор ирсэн монголчууд ХҮ жарны цагаагчин гахай жилд (1911 он) харийн эрхшээлээс гарч үндэс угсаагаа чөлөөлөх их тэмцлийг өрнүүлэн, улмаар тэрхүү тэмцэл нь Халх Монголд амжилтанд хүрч, туурга тусгаар улсаа байгуулахдаа Хаант Орос улсыг өмөг түшгээ болгохоор шийдэж түүнээс удаа дараа тусламж эрсэн билээ.

Хаант Орос улс нь 1904-1905 оны Орос - Японы дайнд ялагдаж улмаар Манжуурын хэсэг дэх төмөр замаа Японд алдсаны дараа оросууд эх газрын Ази руу анхаарлаа хандуулахад хүргэсэн нэгэн зүйл бол 1907 оны Япон - Оросын нууц хэлэлцээрээр Монголын газар нутгийг нөлөөнийхөө хүрээнд хуваан авсан явдал байлаа. Тийнхүү нөлөөний хүрээгээ хуваан авахад Өвөр Монгол- Японы, Ар Монгол - Хаант Оросын нөлөөний бүс хэмээн харилцан тохиролцжээ. Япон улс нь XIX зууны сүүлчээр хөрөнгөтний замаар эрчимтэй хөгжиж, улмаар өөрийнхөө хүчин чадалд тохирсон байр суурийг Зүүн хойд Азид эзлэхийг ихэд эрмэлзэж, амжилттай дэвшиж байсан үе юм. Тиймээс зөвхөн Чин гүрэн өрнөдийнхний колонийн бодлогын объект болоод зогсохгүй мөн Монгол орон ч Их гүрнүүдийн гадаад бодлогын анхаарлын объект болж байв.

Оросын зүгээс эх газрын Ази, тэгэхдээ чухамдаа Монгол руу хандсан бодлогоо эргэн харахад хүргэсэн нэгэн чухал зүйл бол Чин улс болон Оросын “Санкт Петербургийн худалдааны гэрээ”-ний хугацаа дуусч байсан явдал юм. Хятадтай хийж буй Оросын бүх худалдааны үнэмлэхүй дийлэнх хувь Монголын газар нутгаар өнгөрч байв. Хятад газар Чингийн засаглалын хувь заяа эгзэгтэй болж ирж байгааг Оросын төр мөн ч сайн мэдэж байв.

Монгол - Оросын улс төрийн харилцааны түүхэнд холбогдох асуудал буюу Монголын тусгаар тогтнолын үйл хэргээр анх хэдүйд Орост хандсан тухай асуудлаар манай түүхчид

¹ ШУТИС-ийн НТС-ийн ахлах багш, докторант

судлан бичсэнийг үзвээс 1900 онд Богд гэгээнтэн өөрийн нэрийн өмнөөс Хаант Оросоос мөнгө зээлэх асуудлаар шанзудба Бадамдорж тэргүүтэй элч төлөөлөгчдийг Оросын эзэн хаан руу илгээжээ. 100 мянган рубль зээлье гэсэн хүсэлт тавихад 30000 рублийн зээл олгохоор шийдвэрлэсэн боловч уг мөнгийг Жибзундамба хутагт аваагүй байна.

Оросын тал зээлийн мөнгөний эргэн төлөгдөх нөхцөлд нэлээд анхаарал тавьж байсан бололтой зүйл уг зээлийг олгох талаар Оросын эрх баригчид өөр хоорондоо харилцсан бичигт: “Мөнгө зээлдүүлэхийг хүссэн Хутагтын бичигт Эрдэнэ Шанзудбын яамны том тамга дарж, Хаант Оросын Хүрээн дэх консулын гэрчилсэн гарын үсэг зурсан. Хутагт нь 10000 шавь нар болон олон мянган мал сүрэгтэй. Жил бүр Богдод мөргөхөөр Манжуураас Ладака, Кашмир хүртэлх газар нутгийн олон мянган буддын шашинтнууд ирдэг” хэмээн дурьдсанаас үзэхэд илэрхий байна. Энэхүү бичигт мөн “...тэд ноднин жилээс, ядаж 30 мянган рублийн зээлийг удаан хугацаагаар төлж дуусгах нөхцөлтэйгээр зээлдүүлэхийг хүсээд байгаа юм” гэж дурьдсанаас үзэхэд 1899 онд мөн мөнгө зээлэх асуудлыг Оросын талд тавьж байсан байна. Ингээд 1900 онд мөнгө зээлэх хүсэлт тавихад Оросын тал нааштай хандсан нь монголчуудын хятадуудад тавьсан өрийг төлүүлэхэд биш харин монголчуудын хандлагад барьсан хариу гэлтэй гэж үзэх нь зүйтэй болов уу?

Хүрээн дэх Оросын консул Монголд өрнөж байгаа бүхий л үйл явцыг сайтар ажиглаж байв. Хүрээн дэх Оросын консул П.Шишмарёв мэдээлснээр: “Энэ үед 1908 онд Хүрээ - Хаалганы хооронд төмөр зам тавих, уул уурхайг хөгжүүлэх тухай төсөл яригдаж, мөн Монголын төлөөлөгч ирээдүйд байгуулах төлөөллийн байгуулалд оролцох тухай зэргийг Монголын ноёдтой хэлэлцэхийг Бээжингийн Засгийн газар Хүрээний амбанд даалгаад чухам юуны учир Монголын тал тэдний шинэтгэлийн бодлогыг эсэргүүцээд байгааг тодруулахыг түүнд даалгажээ. Монголын ноёд нь эдгээрийг хэлэлцэх нэрийдлээр байн байн цугларан хуралдаж, тэдний (Манжийн-Г.Ц.) явуулах гэж байгаа бодлого нь бидний нүүдэлчин ард түмэнд тохирохгүй хэмээн өөрсдийн байр суурин дээр баттай зогсож байлаа. 1909 оны хавар тэднийг хуралдуулахаар Хүрээнд дуудан ирүүлэхэд тэд төмөр замын тухай асуудлыг хэлэлцэх шаардлагагүй хэмээн мэдэгджээ. Гэвч Бээжингээс заавал барих шаардлагатай гэсээр байжээ. Монголын эрх баригчид тухайн үед төмөр зам тавих юм бол үүнийг дагалдан колоничлогдох явц төдий л хурдан явагдана гэдгийг маш сайн ухаарч байжээ.

Хаант Оросын зүүн өмнөт хилийн ротмистр Баранов: “Монголын асуудал: түүний шалтгаан ба өрнөлт” гэсэн өгүүлэлдээ: “Монголын асуудал нь Монголын улс төр - эдийн засгийн сэдэлттэй тэдний нийгэм, бэлчээрийн амин чухал асуудлыг хөндөж байгаа учраас нийт ард түмэн, нийт үндэстэн, хүн бүхний эрх ашгийг хөндөж байна. Тиймээс ч олон зуун жил дадсан амьдралын хэв маяг, соёл, шашин шүтлэгийг нь эвдэх гэсэн манж нарын оролдлого бүх ард түмний ухамсар сэргэхэд хүргэж байна” хэмээн зөв зүйтэй дүгнэн бичсэн байна.

XX зууны эхэн үеэс Чин гүрнээс Монгол орныг захиран баримтлах бодлогоо эрс өөрчлөн, түүнийг илт колоничлох зорилготой “Шинэ бодлого”² хэмээх бодлого хэрэгжүүлж эхэлсэн тэр үед угаас харийн эрхшээлийг харилхаж байсан монголчууд үндэсний тусгаар

² Энэ бодлогыг монголчууд «Шинэ засгийн бодлого» хэмээн нэрлэдэг

тогтнолын төлөө тэмцлийг шинэ шатанд гаргасан хэмээн судлаачид үздэгтэй миний бие санал нэг байна. Хэрэг явдлын өрнөлт үүнийг бэлхнээ илтгэнэ.

Монголын ихэс дээдэс нар цагаагчин гахай жилийн (1911) зун Богд гэгээнтэнд Бат Оршил өргөхөөр Их Хүрээнд хуран цугларсан үеэр Эрдэнэ шанзудбын яаманд “ШЗБ”-ыг хэрхэх талаар хэлэлцэх хуралдаан хийжээ. Үүний ялдамд долоодугаар сарын 27-28-нд тус зөвлөгөөнд оролцогч хэсэг ихэс дээдэс нар Хан хайрхны Нүхтийн аманд нууцаар хуралдаж Монгол Манж Чин улсаас салан тусгаарлаж, бие даасан улс байгуулах тэмцэлдээ хойт хөрш Хаант Орос улсаас тусламж гуйх хэлэлцээ хийх тусгай төлөөлөгч одуулах шийдвэр гаргажээ.

Ингээд чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд, Өвөр Монголын түшмэл Хайсан нарыг Орос улсаас тусламж эрэхээр явах төлөөлөгчөөр томилохыг Жибзундамба хутагтад мэдүүлж тогтоолгоод Их Хүрээний Оросын консулд учрыг хэлж хил нэвтрэх зөвшөөрөл 8 хүнд авсан байна. Үүнд: ван Ханддорж, да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан, залан Ерөөлт, эмч Жамба, залан Гомбосүрэн, хаалгач Мөр, хиа Лхамжав нар одож, замдаа буриад Авдиеваар хэлмэрчлүүлж явжээ.

Төлөөлөгчид Халхын Жибзундамба хутагт ба Халхын дөрвөн хан нар монгол үндэстэн нь Манж Хятадын дарлал дор тэсэшгүй болсон учрыг гаргаж, тусгаар улс байгуулахад тусламж хүссэн бичгийг Орос улсын эзэн хаанд өргөсөн байна.

Тусламж гуйж өргөсөн бичигт Манжийн төрийн бодлого өөрчлөгдөж байгаа нь Монголд маш харш болж байгааг дурьдаад: “...урьд ноёдын гуйснаар Их улсад түшиж бага улсын ёсоор харилцан туслалцваас бидний хуучин хэв суртал алдагдахгүй бөгөөд шарын шашин нэн бадарч ашид амар тайвнаар байна. Ийм санаа хүсэлтэй нь Өвөр Монголд үлэмж бий. Эдүгээ учрыг гаргаж туслах хамгаалахыг эрсүгэй хэмээн олноор санаа нийлж зөвлөлдөн тогтсон...” гээд Богд гэгээнтний санааг бичгийн төгсгөлд: “... лам би санаваас урьд хожид байдал төлөв үнэн бөгөөд миний санаа мөн адил. Хянахад олон улсын тогтсон хуульд аливаа дор бага улс болбоос чийрэг их улсыг шүтэж өөртөө тогтнох, чийрэг их улс болбоос дор бага улсыг тэтгэн туслах ёс бий тул учрыг гарган бичиг өргөж ...зарсны тулд Их Хаан үнэн байдал төлвийг нэвт тольдож агуу өршөөлөөр нигүүлсэн үзэж даруйхнаа хамгаалан туслахыг их ганд бороог хүсэх мэт сүслэн гуйж чин үнэнийг илрүүлэн өчүүхэн бэлэг сэлтийг хичээнгүйлэн өргөв” гэжээ. Ийнхүү өөрсдийн байдлыг тодорхойлон бичихийн зэрэгцээ Орос улсаас урьд тусламж эрж байснаа бас сануулжээ.

Төлөөлөгчид мөн “Хятад түшмэд Манж улсын эрхийг эдэлж, эрт эдүгээд олон монгол хилс бэрхээр дарлан зовоож хашруулан бүхий учрыг эдүгээ бидний мэдсэн, амссан төдийгөөс товчлон гаргаж мэдүүлэх нь” гэсэн 21 зүйл бүхий бичиг авч явжээ. Энэхүү бичгийн гарчиг нь тэр үед Чин улсын бүх эрх хятад түшмэдүүдийн гарт орж Манжийн төрийн бодлого нь хятад үндэстний бодлого болон хувирсныг илтгэжээ. Бичгийн эхний 15 зүйлд Манж хятад түшмэдийн зүгээс монгол ноёдын эрх ашгийг хэрхэн хөсөрдүүлж, шашин шүтлэгийг нь доромжилж улмаар монголчуудыг илт хятадчилах бодлого явуулах болсныг илтгэхийн ялдамд эл бодлого нь Орос улсад ч халгаатайг ийнхүү дурьджээ:

- “Хилийн орчмоор хятад иргэдээр тариа тариулах, монгол цэргийг татаж хятад цэрэг суулгах болсон нь манай Орос, Монгол хоёрын харилцан туслалцах явдлыг таслая хэмээсэн

маш хортой санаа билээ.

- Манай Орос, Монгол хоёрын найрамдах цаг болсон. Хэрэв энэ сайн тухай үеийг алдваас хожим аль ч этгээдийн хэрэг бүтэх үгүйг гэмшвээс гүйцэх үгүй болох

- Хятад хүн болбоос төрөлх чанар муу урвах дуртай. Хэрэв манай Халхын хойд хязгаар тултал хятадыг тариалан суулгаваас эртнээс найр найрамдахаар ирсэн их улс лугаа магад завшин халдаж манай Монголыг дагалдуулан нөхөшгүй хор зовлонг амсуулахад хүргэнэ” хэмээжээ. Тэгээд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай гэрээ байгуулах, тэрхүү гэрээндээ Оросын худалдаа гүйлгээ, төмөр зам тавих, шуудан харилцааг өргөтгөх, алт мөнгө зоорь нээлгэх, бичиг цэргийн сургууль байгуулах зэрэг асуудлыг тусгасан санал тавьжээ. Эцэст нь Хятадын худалдааг тус орноос гаргаж Оросын худалдааг оруулахаар зөвлөн тогтож байна гээд: “Ганц худалдаа арилжаа хэмээгч олны аж төрөх амьдралд холбогдох чухал хэрэг мөн тул орос худалдааг одоо манай монгол газар яахин цэргээр хамгаалуулан аргацаан оруулахыг урьдаар бэлтгэх аваас болох болбуу?” гэж эдгээр зүйлүүдээр тусгай гэрээ хэлэлцээр тогтоож болно гэдгийг Оросын хаант засагт урьдчилан мэдэгджээ.

1911 оны 8 дугаар сарын 3 (хуучин тооллоор- Ц.Г.)-ны өдөр Сайд нарын Зөвлөлийн хуралдаан дуусмагц Монголын асуудлыг хэлэлцэх тусгай зөвлөгөөн болно гэдгийг зарласан бөгөөд түүнд Сан, Худалдаа, Аж үйлдвэр, Гадаад явдлын ба Цэрэг Тэнгисийн яамдын сайд нар болон бусад өндөр тушаалтнууд оролцож, Монголын талаар баримтлах чиг шугамаа тогтоосон байна. Наймдугаар сарын 17-нд Засгийн газартаа Монгол - Хятадын хооронд зуучилж, Монголын ноёдод дипломат дэмжлэг үзүүлэхийг зөвлөжээ.

Тэр үед Чин улсаас Монголд явуулж буй бодлого, түүний хөрш Орос улсын эрх баригчдын анхаарлыг зүй ёсоор татаж байсныг дээр цухас дурьдсан билээ. Орос улс Ойрхи, Дундад, Дорнодод гол анхаарлаа чиглүүлж, Германтай хийх дайнд бэлтгэж байсан болохоор Алс Дорнодод бат ар талтай байхыг хичээж байжээ. Иймээс Монголын асуудал хэлэлцсэн онц зөвлөгөөний тогтоолд “... монголын асуудал бидэнд их ач холбогдолтой байна” гэж тэмдэглээд уг асуудалд хэрхэн хандахаа: “...Монголын асуудалд идэвхтэй оролцохгүйгээр... тэр хоёрын (Монгол, Чин улсын- Ц.Г.) хооронд зуучлан, Монголоос Чин улстай тогтоосон (сюзерений эзэн эрхийн- Ц.Г.) холбоог таслалгүйгээр үндэсний байдлаа хамгаалах гэсэн монголчуудын эрмэлзлэлийг дипломат замаар дэмжих” хэрэгтэй гэж тодорхойлжээ. Үүний дагуу Орос улсын эрх баригчид, Монголын төлөөлөгчдөд Монгол одоо үед Чин улсаас бүрэн тусгаарлах бололцоогүй, харин Монголд хийж байгаа шинэчлэлтийг болиулах талаар Бээжинд мэдэгдэл хийнэ. Хятадын талаас Монголчуудын эсрэг хийж болзошгүй аллага хядлагаас өмгөөлнө гээд эл байдал хийгээд төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангахын тулд Их Хүрээнд байгаа Консулын газраа харгалзах цагдаагийн хүчийг зузаатгахаар пулемёт буу бүхий 200 казак цэргийг нэмж явуулахаар амалсан байна.

Ийнхүү Оросын зүгээс Монголд шууд тусламж үзүүлэхээс зайлсхийсэн хариу өгсөн нь Монголын асуудлаас болж Хаант Орос их гүрнүүдтэй харилцах харилцаандаа сэв суулгахыг хүсэхгүй байсанд оршино. Гэхдээ монголчууд тийнхүү түүн рүү хандсан явдлыг бас огт тоохгүй өнгөрөөх сонирхолгүй байсан нь тэдний өгсөн хариунаас илт байна. Учир нь:

- Хаант Орос Монголыг өөрийнхөө нөлөөний бүс гэдгийн талаар Японтой хэлэлцэн тохиролцчихсон,
- Монгол орны зах зээлийг судлуулахаар илгээсэн удаа дараагийн экспедицийн тайлан дээр зохих дүгнэлт хийж, Монголын зах зээлийг алдахгүй байх бодлогоо тодорхойлж байсан үе
- Монголын газар нутаг стратегийн болон геополитикийн чухал орон зай. Хэрэв Монголыг Хятадад алдвал тус улс Хятадтай шууд хил залгах болно. Энэ нь аюул нүүрлүүлнэ.
- Оросоос Төв Азитай худалдаа арилжаа хийх гол дамжин өнгөрөх нутаг дэвсгэр болж байсныхаа хувьд Монголын хандлагад зарим талаар нааштай хандах нь ирээдүйд түүнд ашиг хонжоо авчирна гэдгийг маш сайн тооцоолжээ.

Ингээд 1911 оны намар гэхэд Үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл өрнөлтийнхээ үед орж, хувьсгалын удирдагчид нэгдэн нягтарч, хувьсгалын үйл хэргийг удирдан зохион байгуулах төв штаб- Халхын Хүрээний Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Шийтгэх Газар байгуулагдаж, хувьсгалт арга хэмжээнүүдийг дэс дараалалтай авч хэрэгжүүлж улмаар өвлийн дунд сарын шинийн найманд (1911.12.29) Монголын шарын шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагтыг туурга тусгаар Монгол улсынхаа эзэн хааны сэнтийд залж, таван яам бүхий байнгын ажиллагаатай Засгийн газрыг байгуулжээ.

Монголын төрийн тусгаар тогтнол бол зөвхөн монголчуудын тэмцэл чармайлт, арга сүйхээний гол үр дүн байв. Харин олон монголчуудын хүсэл тэмүүлэл цаашид хэрхэх нь хоёр хөрш орны гадаад бодлогоос ихээхэн шалтгаалсан зүйл байлаа. Монгол орон эх газрын түгжидмэл байдалд олон зуун мянган жил оршин тогтносоор ирсэн билээ. Харин сүүлийн үед хоёрхон оронтой хил залгадаг болсон Хятадтай 4100 вёрст, Хаант Орос улстай 2900 вёрст мод газраас хиллэдэг бөгөөд энэ байдал нь Монголын нүүдэлчдийг өмнөт болон хойт хөршийн худалдааны капиталын байнгын дарамтанд байхад хүргэж байлаа. Улмаар өмнөт хөршийн зүгээс Монгол орныг колоничлох бодлого явуулж эхэлмэгц монголчууд нь өөрийн эрхгүй аврал, тусламж хайж хойт хөрш рүүгээ хандахад хүрсэн билээ.

Ар Монголд үндэсний эрх чөлөөний тэмцэл өрнөж эхлэхэд Чин улсад байсан Оросын дипломат агентууд тэрхүү улс төрийн үйл явцыг зүгээр нэг ажиглах, монгол ноёдын хүсэлтийг дамжуулагч байгаагүй нь ойлгомжтой.

XIX зууны 90-ээд онд Төвд эмч Бадмаеваас III Александр, II Николай болон Сангийн сайд С.Ю. Витте нарт бичсэн захидлуудад: Монгол, Төвд, Хятадын зарим хэсгийг Хаант Орост нэгтгэх тухай санал тавихад III Александр хаан өөрийн гараар дараах зүйлийг тэмдэглэсэн байдаг. "...энэ бүхэн яасан хачин шинэ бөгөөд мөрөөдлийн юм шиг юм бэ, үүнд амжилт олох боломж бий гэхэд итгэхэд бэрх" хэмээжээ.

Оросын зүгээс Монголд найрсаг, ая тал алдалгүй хандаж ирсэн байдал нь хэзээ нэгэн цагт өөрт нь ашиг хонжоо өгөх зүйл байлаа. Тиймээс ч Богд Жибзундамба болон монгол ноёдын тусламж эрсэн хүсэлт нь Хаант Оросын хувьд гэнэтийн зүйл биш байжээ. Бээжингийн Засгийн газрын Монголын талаарх бодлого нь юуны түрүүнд Монгол руу илүүдэл хүн амаа оруулах, Монголын зах зээлийг эзлэн авах гэсэн Хятадын худалдааны капиталтнуудын бодлого байлаа. Тэд энэ бодлогоо хэрэгжүүлснээр Оросын хилээр өөрийн жийргэвч буй болгох санаатай байв.

Харин Оросын капиталын хувьд гэвэл оросууд нь анх Монгол орон руу өөрсдийн дур хүслээр эрсдэн орж ирж байжээ. Монголын асуудалд Хаант Орос идэвхгүй байр суурь баримтлах явдал 1910-аад оноос өөрчлөгдөж ирсэн. Бээжин дэх Оросын Элчин сайд Коростовец нөхцөл байдлыг ашиглан Монголын асуудалд идэвхтэй байр суурь эзлэх нь зүйтэй хэмээн үзэж Гадаад хэргийн яамандаа мэдэгдсээр байжээ. Тэрбээр Манж Чин улсаас Монголд явуулж буй Шинэ засгийн бодлоготой холбогдуулан Япон болон Англитай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр тэдний дэмжлэгийг авч Хятадад дарамт үзүүлэн Монголын status quo-г хэвээр үлдээж улмаар тэнд хийхээр завдаж буй цэргийн шинэтгэлийг нь зогсоох санал тавьсан байна. Гэвч Оросын засгийн газар Хятадад нөлөөлөх шийдвэртэй арга хэмжээ авах нь тэр үеийн байдлаар маш аюултай байна. Үүнд:

- нэгдүгээрт: Хятадад үймээн самуун гарахад хүргэвэл,
- хоёрдугаарт: ингэснээр Хятадыг АНУ-д алдахад ч хүргэнэ. Ер нь Хятадыг зөвхөн Америк ч биш Европын их гүрнүүд их сонирхож байгаа шүү дээ хэмээн үзэж байжээ.

Оросын Гадаад хэргийн яамны Монголын талаарх байр суурь Коростовецийн 1911 оны долоодугаар сарын 27-ны №1047 цахилгаан утсанд тод тусгагдсан байдаг. Түүнд: “Халхын дотоод байдал нь бидний амин чухал эрх ашгийг хөндөхгүй байгаа бөгөөд Монголын асуудал нь Хятад дахь бидний улс төрийн асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болох хэрэгсэл болж байгаагийнхаа хувьд чухал болж байгаа юм” гэжээ. Дээр өгүүлсэн бүхнээс үзэхэд Монгол нь удаан хугацааны туршид Хаант Оросын Алс Дорнод дахь улс төрийн бодлогын анхаарлын төвд байгаагүй бөгөөд гагцхүү XIX зууны сүүлч, XX зууны эхэн үе болж Монгол орон нь империалист гүрнүүдийн анхаарлыг татах болсон үеийн эхэн хүртэл Оросын Засгийн газарт энэ бүс нутаг дахь өөрийн бодлогыг идэвхжүүлэх улс төрийн болон стратегийн сонирхол байгаагүй бололтой. Орос- Японы дайнд Хаант Орос ялагдал хүлээсэн явдалдаа дүгнэлт хийж мөн Дорнод Хятадын төмөр замын асуудалтай холбогдуулан Орос нь Алс Дорнодын бодлогодоо анхаарал тавих болсныг бид дээр цухас дурьдсан билээ. Ялангуяа Оросын худалдаа, аж үйлдвэрийн капиталыхан Монголын зах зээлийг сонирхох явдал бидний өгүүлэн буй үед өсөн нэмэгдсээр байв. Тэд Хятадын худалдаа- мөнгө хүүллийн капиталтай өрсөлдөн Монголын зах зээлд орж ирсээр байв. Эдгээр үйл явдлыг Оросын судлаачид өөрсдийн бүтээлүүдэд нилээд дэлгэрэнгүй авч үзсэн байдаг.

Алс Дорнодод Оросын геополитикийн орчин нэн эгзэгтэй болж Оросын үндэсний эрх ашигт хамаарах зүйлс их болсонтой холбогдон цэргийнхэн ч бичиж, Орос - Хятадын харилцааны асуудалд өөрийн орны цэрэг- стратегийн эрх ашгийн үүднээс хандахад Монголын асуудал өөрийн эрхгүй тэдний хараан дор оржээ.

XX зууны эхний арван жилийн статистик мэдээгээр Монголд үйл ажиллагаа явуулж байсан Оросын томоохон пүүсийн дундаж эргэлт 500 мянган рубль, багаахан пүүсийн эргэлтийн капитал 20 мянган рубль орчим байв. Энэ бол маш бага тоо юм. Нөгөө талаар оросын худалдаачид тус оронд энд тэндгүй нэвтэрсэн Хятадын худалдаа мөнгө хүүллийн капиталтай халз тулгарч байв. Тиймээс Монгол Чин улсаас салан тусгаарласан нөхцөлд дээрхи байдлыг сайжруулах таатай нөхцөл бүрэлджээ.

1909 онд Оросын Худалдаа аж үйлдвэрийн яамны дэргэд Монголын зах зээлийг

судлах баримт цуглуулах зорилготой тусгай зөвлөл байгуулагджээ. Тэр үеийн тогтмол хэвлэлийн хуудаснаа Монгол дахь Оросын худалдааны хувь заяаны тухай бичсэн зүйл байнга гарч байв. “Оросын экспортын нийгэмлэгийн” удирдах зөвлөлийн гишүүн Рябушинский Монголын асуудлаарх Оросын байр суурь, хүнд суртлыг хурц шүүмжилж байжээ. Монголын зах зээлийг судалсан экспедицууд Монгол дахь Оросын худалдаа маш хүнд байдалд байгаа, гадны капитал түүнийг байнга шахаж байгаа, түүхий эд мал худалдан авах явдал нь хүртэл хэцүү байдалд улам бүр орсоор байгааг дурьдаад хэдий байдал тийм байгаа ч гэсэн Монголын зах дээр ноёрхож байгаа Хятадын капитал давуу талаа бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Тиймээс бид яаралтай хөдлөх хэрэгтэй гэж үзжээ. Тэд, тухайлбал:

- М.Боголепов, М.Соболев нар хэрэв хятадууд Хүрээ, Хаалганы хооронд төмөр зам байгуулчихвал Оросын худалдаа сүйрэлд орно. Хятадын худалдаачид бол Англи, Америкийн үйлдвэрийн эздийн зуучлагч нар юм. Монголын зах зээлд хятадууд дангаараа ноёрхоно гэдэг бол угтаа англи, америкчуудын ноёрхол гэсэн үг гэж үзжээ.

- Оросын Худалдаа Аж Үйлдвэрийн яамны түшмэл А. Болобан Монголоор аялаад буцахдаа Хиагт Хүрээний хооронд автомашины зам тавигдаад тэр нь германчуудын гарт орвол Оросын худалдаанд цохилт болно

- Гүн Беннигсен Оросын хил дээр хятадууд цэргийн суурингууд байгуулж байгаа мөн л аюултай болохыг сануулж байв

- Беннигсен, Болобан болон мөн монголоор аялсан жуулчин Кушелёв нар оросууд цаг хугацаа алдалгүй Орос - Монголын банк байгуулах хэрэгтэй хэмээн үзэж байжээ. Тэдний тооцоолсноор монголчууд Хятадын мөнгө хүүлэгч нарт 12 сая рублийн өртэй. Үүнд Хүрээн дэх Дайчин улсын банк гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэрхүү банкинд зөвхөн ноёдын тавьсан өр 1 сая рубльд хүрч байжээ.

Ийнхүү оросууд Монгол руу ямар ч зохион байгуулалтгүй, өөр өөрийнхөөрөө уван цуван орж ирж байсан явдал өөрчлөгдөж Оросын худалдаа аж үйлдвэрийн хөрөнгөтнүүд Монголын зах зээлийг ихэд сонирхох болсон нь Орос-Монголын харилцаанд шинэ хандлагыг буй болгож, Хаант Оросын Гадаад хэргийн яамнаас Монголын асуудалд оролцохгүй байх зарчим баримталж байсан явдал аажимдаа өөрчлөгдөхөд хүргэжээ. Чухам яг энэ үед Богд Жибзундамба тэргүүтэй Монголын ноёд Хаант Орос улсад хандаж тусламж хүссэн билээ.

Эдийн засгийн хүчин чадал нь бага буурай бөгөөд эх газрын түгжигдмэл байдал нь Монгол орныг их гүрнүүдийн тэмцлийн талбарын төвөөс алсдуу байлгаж байсан нь тус оронд өрнөсөн хувьсгалт үйл явц болон Монголын асуудал нь орон нутгийн шинж чанартай мэт байсан боловч энэ бүс нутагт Хаант Орос болон Хятад гэсэн хоёр их гүрний эрх ашиг хөндөгдөж байсан учир Монголын асуудал гэж харийнхан нэрлээд байсан тэрхүү үндэсний эрх чөлөөний төлөөх хувьсгалт тэмцэл нь амжилтанд хүрч монголчууд төрийнхөө тусгаар тогтнолыг тунхаглан зарласан явдал зөвхөн нэгэн улс үндэстний асуудал биш харин олон улсын шинж чанартай болж, улмаар түүнийг хэн нь илүү сорон мөлжихийн төлөө тэмцэл болж хувирсан байна. Тиймээс ч Хаант Орос Монголд зэр зэвсэгээр туслахаар шийджээ. Ингээд Оросын капитализм шинэ талбартай болмогц түүнийгээ зохион байгуулах ажилдаа

оржээ.

Хаант Оросулс Монгол улсыг автономит улс болгох, чингэхдээ гэрээ хэлцэл байгуулж тус орон дахь Оросын иргэдэд онцгой давуу байдал болон зарим хөнгөлөлт үзүүлэх, мөн тус орныг удирдах хэрэгт Оросын төлөөлөгч байлгах... Чингэхдээ тус улс орныг удирдах болон бусдаас хамгаалах хүнд үүргийг өөрийн засгийн газарт ноогдуулалгүй, гагцхүү улс төр ба стратегийн жийргэвч болгож, түүнээс эдийн засгийн ашиг олж байх бодлогыг анхнаасаа эхлэн баримталсан байна.

Тусгаар тогтнолоо олж авсны дараа ч, 1913 онд Оросын худалдаа аж үйлдвэрийн яам тус орон руу зах зээлийнх нь багтаамжийг судлах экспедиц илгээсэн, мөн түүнчлэн хожим нь 1915, 1916 онуудад С.А.Козин, П.А.Витте нарын экспедициуд, 1919 онд И.М.Майскийн экспедиц нь Монголын талаар нилээд дэлгэрэнгүй судалгаа хийсэн байдаг.

Хаант Оросын Монгол дахь эдийн засгийн бодлогыг боловсруулсан хүн бол Гадаад хэргийн яамны сайд С.Д.Сазонов байсан бөгөөд түүний бодлого нь Монголын зах зээлийг сонирхож буй Оросын худалдаа аж үйлдвэрийн хөрөнгөтнүүдийн эрх ашгийг илэрхийлж байв. Сангийн яамны сайд В.Н.Коковцев Оросын томоохон хөрөнгөтнүүд, помещикуудын эрх ашгийг илэрхийлэн Монголд “Монголор” шиг олборлолтын үйлдвэрийн том газруудыг нэмж байгуулах, Оросын худалдаачдад Монголд монополь эрх олгож, тэдэнд газар эзэмших өргөн эрх олгох, Монголын зах зээлд гадаадын худалдааг оруулах гэх мэт зүйлийг Сазоновын хөтөлбөрт нэмж оруулах саналтай байв. Гэтэл Гадаад хэргийн сайд Сангийн сайдын саналыг эсэргүүцэж Орос нь Монголд эдийн засгийн үйл ажиллагаа явуулахдаа тун болгоомжтой байх ёстой. Учир нь Хятад болон өрнөдийн гүрнүүдийн дургүйцлийг төрүүлэх алхам хийх явдал Оросын дипломатын төлөвлөгөөнд байхгүй хэмээн мэдэгдэж байжээ. Монголын асуудлаарх хоёр сайдын баримтлалыг II Николай хаан эцэслэн тогтоожээ. В.Н.Коковцевын С.Д.Сазоновд, түүний Монголыг автономит улс болгох төсөл бол алдаатай зүйл гэдгийг ойлгуулах гэж бичсэн захидлын булан дээр II Николай хаан: “Чухам энэ байгуулал нь бидэнд улс төрийн хувьд ашигтай” хэмээжээ.

Туурга тусгаар болсон Монгол улс нь Хаант Оросын хувьд Алс Дорнодод үйл ажиллагаагаа явуулах нэгэн талбар нь болсон юм. Бамбай улсынхаа олон улсын эрх зүйн байдлыг нь бүрдүүлэх, өөрсдийн цэргийн зөвлөхүүдээр дамжуулан цэргийн хүчин чадалд нь санаа тавих, өгсөн зээлээ эргүүлэн авах нөхцлийг тус оронд бүрдүүлэх үүднээс өөрийн санхүүгийн зөвлөх нарыг илгээх, байгалийн баялгаас олох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж Хаант Орос нь анхандаа Монгол руу идэвхтэй, зохион байгуулалттай нэвтэрч орж ирсэн ажээ. Оросын худалдаа, үйлдвэрлэлийнхэн эхэн үед гайхамшигтай сайхан нөхцөл хүлээж байв. Туугдан гарсан хятадуудын өмчийг бараг үнэгүй шахуу авч улмаар тэдний байр суурийг эзлэн авах мөн монголчуудын оросуудад талархсан сэтгэл дээр дөрөөлөн тус улсад монополь эрх олж авах сайхан ирээдүй нээгдэж байв. Гэтэл энэ нь зөвхөн ирээдүйн тухай төсөөлөл байлаа. Жилийн дараа огт өөр дүр зураг тодорчээ. “Оросын экспортын нийгэмлэг”-ийн 1913 оны тайланд: “...тус нийгэмлэгийн салбарыг Хүрээнд нээснээс хойшхи нэг жилд тус орныг Оросын бүтээгдэхүүнийг борлуулах зэх зээл болгох гэсэн тэр горьдлого талаар болов” хэмээн дүгнэн бичжээ. Мөн Болобан эх орондоо хариад: “Монголд хаа сайгүй Оросын

худалдаачдад гомдол гаргаж, хятадууд байхад арай дээр байсан” гэгцгээж байна гэж мэдээлж байжээ. Эл үед Оросын бараа таваар Монголын зах зээлийн дөнгөж 30 - 35 хувийг хангаж байжээ. Гэтэл оросуудад үүнээс илүү боломж байсан ажээ. Учир нь эл үед хятадууд Хаалганаар гарах жингийн цувааны тоог хорогдуулсан байсан бөгөөд монголчууд тусгаар тогтнолоо тунхаглаад Хятадын бараа таваарт 5 %- ийн татвар оноох болсон аж. Гэтэл 1912 оны Орос - Монголын гэрээгээр Оросын худалдаанд ямар ч татвар оногдохгүй болсон ажээ.

Ингээд 1912-1915 онуудад Орос - Монголын худалдаа маш өргөн дэлгэр хөгжиж зөвхөн тооны хувьд өссөн төдийгүй чанарын хувь өөрчлөлт гарсан байв. Энэ үеийн гол онцлог бол Орос - Монголын худалдааны байгууллагууд бий болов. 1912 оны 4-р сарын 12-нд Нийслэл Хүрээнд орос худалдаачдын санаачлагаар “Орос - Монголын агуулахын нөхөрлөл”, “Москлагийн экспортын нөхөрлөл” байгуулагджээ. Мөн шинээр байгуулагдсан “Орос - Монголын акцийн нийгэмлэг”-ийг өргөжүүлэн, үндсэн капиталыг нь 5 сая рубль болгож, түүнд Хиагтын Коковин ба Басовын худалдааны пүүс, Бийскийн биржийн тэргүүн А.Д.Васильев, Семипалатинскийн биржийн хорооны Б.Ф.Плещеев нарыг оруулан Монголтой хийх худалдаагаа өргөжүүлж, Монголоос оруулах түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах, зам харилцааг сайжруулахад зарцуулах мөнгийг Сибирт байршуулан, хэрэв хөрөнгө мөнгө дутагдвал гадаадын хөрөнгө оруулах асуудлыг Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаараа хэлэлцэж шийдвэр гаргаж байв.

Монгол орон дэлхийн зах зээлд татагдан орохдоо чухамдаа мал аж ахуйгаараа дэлхийн аж ахуйн нийт эргэлтэнд хамрагдсан юм. Хятад, Орос, Англи, Америк зэрэг орны худалдаачид Монголын аж ахуйн хүч бололцоог үл харгалзан зөвхөн аль болохоор их түүхий эд шавхан авах, адуу малыг нь гадагш гаргахын төлөө тэмцэлдэх болжээ. Нөгөө талаар “Монголын аж ахуй гаднаас бараа таваар худалдан авахгүй, мөн өөрийн түүхий эдийг гадагш борлуулахгүй байж үнэхээр чадахгүй болсон хийгээд монголчуудын аж ахуй, зах зээлтэй холбогдож натурал аж ахуйн цэвэр хэлбэр алга болсон байв” гэж 1910 онд Монголд шинжилгээний экспедицээр ирсэн М.И.Боголепов, М.Н.Соболев нар бичжээ.

Монгол орон Сибирь, Эрхүүгийн махны эрэлт хэрэгцээг хангах хэрэгт чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Чуй, Түнхэн, Хиагт, Мондын чиглэлээр мал гаргаж байсан бөгөөд зөвхөн 1911 онд Мондын чиглэлээр 29223 толгой бод мал, 41959 толгой бог малыг Орос руу оруулжээ. Оросын зах зээл дээр Монголын малын эрэлт өндөр байсан учир монголчууд орос худалдаачидтай малын том наймаа гүйлгэх болжээ. Үүнтэй холбоотой малын панзчид үүсчээ. Сайн ноён хан аймгийн Далай ван Цэдэнсодномын хошууны сумын занги Дарамсэнгэ, банди Луузанбазар, хуяг Банзрагч нар Молоток хэмээх Александр нарт үхэр 200 гаруйг, нэг бүрийг 39 рублээр Түнхэнд аваачин худалджээ. 1913 онд Хойт ангийн үржүүлэх адууны түшмэл Цогбадрах гэгч Засагт хан аймгийн гүн Дамдин - Абшаагийн нутагт худалдаалан суугч орос Иванов нарт шар үхэр 52, эр хонь 600 - г 4915 целков цаасаар зарж байжээ. Эдгээр баримтууд нь тус оронд зах зээлийн харилцаа хөгжиж байсныг илтгэж байна.

Монгол улс туурга тусгаар улс болсны үрээр жин тээврийн ажил монголчуудын мэдэлд орж, олон аймаг хошуу болон Монгол, Орос, Хятадыг холбосон 21 чиглэлийн аян

жингийн замаар бараа таваар, мал аж ахуйн түүхий эд, ангийн арьс үс, байгалийн баялгийг тээвэрлэж, түүнээс жил тутам 2 сая шахам рублийн орлого олж байв. Жинчид мал аж ахуй, ангийн түүхий эдийг одоогийн Казахстан, Бийск, Хөшөө мод, Бархөл, Цонж, Хойд Хятад, Өвөр Монгол, Дорнод Манжуурын хотууд хүртэл тээвэрлэдэг байв. Түүгээр ч барахгүй “Хиагт Хүрээ- Чуулалт хаалганы хооронд Оросын шуудан харилцааг дамжуулж байжээ.

Гадаад руу жин тээгчид нь бусдын бараа, түүхий эдийг хүргэхийн далимд өөрсдийн аж ахуйн бага сага түүхий эд, мал зэргийг тэдгээр газар аваачин борлуулах, жингийн хөлс болон борлуулсан зүйлийнхээ хөлсөөр аж ахуйдаа болон арилжаа наймаанд зориулан төрөл бүрийн бараа таваарыг хэр чадлаараа худалдан авч, газар орон үзэж, бусдын соёлтай танилцаж байсан нь дэвшилтэд зүйл юм. Ийнхүү өөрсдийн хүч хөдөлмөр, овсгооны үрээр мөнгөн хуримтлал буй болгож байсан хүмүүс нь нийгмийн давхраажлыг улам бүр идэвхжүүлж байв. Аливаа нийгмийн түүх бол давхраажлын түүх байдаг гэж социологийн шинжлэх ухаан үздэг.

Оросын капитал нь зөвхөн худалдааны салбарт төдийгүй үйлдвэрлэлийн салбарт бас төвлөрч байсан нь дэвшилтэт зүйл байлаа. Эл үед Монголд Оросын 100 орчим ноос угаах газар, 20 орчим арьс шир боловсруулах жижиг үйлдвэр ажиллаж байв.

Тэр үед Монгол Оросын бүхэл бүтэн колони бий болжээ. XX зууны эхээр Орос-Монголын эдийн засгийн харилцаа өргөжсөнтэй холбоотойгоор Оросоос Монголд нүүдэллэн ирж амьдарч байсан оросууд өөрсдийн колонийг байгуулан тус оронд оршин сууж байлаа. Энэ бол эзлэн түрэмгийлэл биш юм. 1860 онд Орос-Манж Чин улсын хооронд Бээжингийн хэлэлцээр болон 1862 оны “Хуурай замын худалдааны” дүрмээр оросууд Монголд худалдаа хийх эрх олж авч, Өргөөд Консулын газар нээгдсэн. 1863 онд Хиагтаар дамжин Монголд 3977 хүн орж ирж тэдний зарим нь тус оронд үлдсэнээр Оросын колоний эх суурь тавигджээ. Улмаар 1917 он гэхэд Монголд 5000 орчим Оросын харьяат орос, буриад, татар, еврей, польш зэрэг хүмүүс байжээ. Түүнээс 2000-2500 нь Нийслэл Хүрээнд амьдарч байжээ.

Оросын Хаант засаг Чин улсаас тусгаарлах хэрэгт “тусалсны” хариуд Монголд үлэмжхэн эрх дарх олж авч, улмаар Оросын худалдаачид, үйлдвэрлэгчид тус оронд ямар ч хориг саадгүй нэвтэрч, ажиллах болжээ. Ингэснээр хоёр орны харилцаа 1912-1915 онуудад нэлээд өргөжсөн байна. Жишээлбэл, Монгол улс тусгаар тогтнолоо зарлахаас өмнө буюу 1911 онд Хиагт хотоор дамжуулан 11 сая 142 мянган рублийн худалдаа хийж байсан бол 1915 онд 15 сая 841 мянган рубль болж өсчээ. Энэ өсөлтөд Монгол улсын эрх баригчид сэтгэл ханамжтай байсан бөгөөд цаашид ч Оростой тогтоосон харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байжээ.

Тухайн үед Монголд ажиллаж байсан Оросын польш эрдэмтэн В.Л.Котвич нэгэн захидалдаа: “Оросын худалдаачин Ф.С.Москвитин 1912 оны хавар Нийслэл Хүрээнд Орос-Монголын Комиссын агуулахуудын нөхөрлөл гэгчийг байгуулахад Дотоод яамны тэргүүн сайд Цэрэнчимэд, Гадаад яамны тэргүүн сайд Ханддорж, Сангийн яамны тэргүүн сайд Чагдаржав, Шүүх яамны сайд Намсрай, Дотоод яамны дэс түшмэл Хайсан гүн нар оролцож байсан” гэж бичсэн нь дээрхийн илэрхийлэл юм. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын нэрт зүтгэлтнүүд ингэж хувь нийлүүлэгчээр элсэн орж, уг нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж

байсан нь Оростой хийх худалдааны харилцааг улам урамшуулан хөгжүүлэх зорилготой байсан бөгөөд чингэхдээ юуны урьд Хүрээнд Оросын барааг хүлээн авч, хадгалах орон байр бэлдэхээс ажлаа эхэлжээ. Мөн 1913 оны II сард Оросын нефтийн бүтээгдэхүүний нэгдлийн захирал Степан Леанозов Их Хүрээ болон бусад боломжтой газруудад нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулах барих зөвшөөрлийг хүссэн тул манайхаас Петербургт очсон төлөөлөгчидтэй уулзаж зөвшөөрөл авч, тэднээс тамга тэмдэг бүхий үнэмлэх бичиг авчээ.

Оросын хөрөнгөтнүүд Монголын зах зээлийг бусад орнуудад алдахгүйг хичээж байжээ. 1913 оны Оросын яамдын нэгэн зөвлөгөөн: "...монголчуудын гол хэрэглээ болсон даалимба болон цэмбийг Монгол руу их хэмжээгээр оруулах талаар манай Москвагийн фирмүүд санаачлага муутай ажиллаж байна. Энэ байдал нь бид зөвхөн Монголын зах зээлийг алдаад зогсохгүй, монголчуудын итгэлийг алдахад хүрнэ. Бид 1 жил Владивостокоор дамжуулан бүүр гадны даалимба оруулж болох юм. Гэтэл энэ саналыг Худалдаа аж үйлдвэрийн яам болон Гаалийн газар зөвшөөрөхгүй байна. Тиймээс Сайд нарын зөвлөлийн хуралдаанаар энэ асуудлыг оруулж Монгол руу Оросын хөвөн даавуун бүтээгдэхүүнийг экспортлох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах хэрэгтэй байна" гэсэн шийдвэрийг гаргажээ. Үүний дагуу 1913 онд Нийслэл Хүрээнд Москвагийн худалдаачдын нөхөрлөл байгуулагдаж, хөвөн бөс бараа худалдаалах болжээ.

1914 онд Бүх Оросын биржийн худалдаа болон хөдөө аж ахуйн төлөөлөгчдийн VIII Их хурал дээр Орос-Монголын худалдааны өнөөгийн байдлын талаар хэлэлцжээ. Москвагийн худалдаачдын экспедицийн мэдээлснээр Оросоос Монголд жилд 30 сая рублийн бараа орж, Монголоос Орос руу 40-60 сая рублийн мал түүхий эд орж байна. Жилийн гадаад худалдааны эргэлт 70- 90 сая рубль болж байна. 1910 онд Орос Монголын худалдааны эргэлт орох нь 2179221 руб, гарах нь 10787839 руб., нийт эргэлт 12967060 рубль болж байгаа бөгөөд энэ нь Монголын гадаад худалдааны 15% болж байгаа билээ. Үүнээс үзэхэд бид боломжийг маш бага ашиглаж, өсөлт маш удаан байна. Гэтэл Монголын урд хилээр Америк, Англи, Герман, Япон, Хятад бараа орж ирж байна. Бид боломжоо муу ашиглаж байгаа нь дараах зүйлстэй холбоотой байна. Үүнд:

1) Монголын зах зээлийн эрэлт хэрэгцээг Оросын үйлдвэрийн эзэд сайн мэдэхгүй байна.

2) Оросын бараа таваар өндөр үнэтэй байна. Оросын барааны өөрийн өртөг өндөр байна.

3) Төмөр зам байхгүй, зам харилцаа муу, шаардлага хангах хэмжээнд биш байна. Москвагаас Хиагтаар дамжуулан Улиастай хүртэл 1 пуд бараа 3 руб. 5 коп. болж байна. Москвагаас Бийскээр дамжуулан Ховд хүрэхэд мөн тийм өртөгтэй байна. Гэтэл Гамбургээс усан замаар Тяньцзин хүргээд Хаалганаар Улиастай ба Ховд хүргэхэд 1 руб. 70 коп-ээс 2 руб. 50 копейк болж байна.

4) Монгол дахь Оросын худалдаачдад зээл олгох санхүүгийн байгууллага байхгүй байна. Мөнгө хүүлэл хийдэг цөөн хэдэн хүн байгаа боловч тэд өөрсдийн эрх ашгийг бодоод өндөр хүү нэхдэг.

5) Хэдийгээр оросууд Монголд эрх дархыг олж авсан боловч үүнийгээ ашиглаж

чадахгүй байна. Учир нь хангалттай бараа таваар оруулж чадахгүй байгаа учраас үнэ өндөр байна. Эл байдал нь монголчуудын дургүйцлийг төрүүлж байна. Ингээд эдгээр байдлыг засахын тулд:

Нэгдүгээрт: Төмөр зам барьж бусад замыг засаж, тээвэрлэлтийн зардлыг багасгах, пудийг нь 3- 5 копейкээр тээвэрлэж байхаар

Хоёрдугаарт: Хүрээ, Ховд, Улиастайд Оросын банк байгуулж, оросууд болон монголчуудад зээл олгох.

Гуравдугаарт: Монголчуудын сонирхлыг татах эрэлт хэрэгцээтэй бараа таваарыг оруулж байх, энэ талаар судалгаа хийх

Дөрөвдүгээрт: Засгийн газрын хийхээр төлөвлөсөн Монгол дахь шуудан, харилцаа холбоог хөгжүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх

Тавдугаарт: Оросын мал эмнэлгийн байгууллагуудыг нэн даруй байгуулах хэрэгтэй хэмээн үзжээ. Энэ мэтчилэн Хаант Оросын Засгийн газар Монголын зах зээлийг эзлэхэд нилээд анхаарал тавьж байжээ.

Ийнхүү Хаант Орос улсын Монголын талаар явуулж байсан бодлого нь нэгдүгээрт: Хятадтай шууд хил залгаа суулгахгүйн тулд Монголыг өмнөт хэсэг дэх жийргэвч бүс болгох, хоёрдугаарт: Ар Монголд нэвтрэн, эдийн засгийн нөлөөг өөртөө ашигтайгаар өргөтгөхийг зорьж байсан учраас Хятадаас тусгаарлах гэсэн монголчуудын хүсэл эрмэлзлэлийг шууд няцаахаас түдгэлзэн түүнийг өөрийн зорилгод ашиглахын тулд хөрөнгө мөнгө, зэр зэвсгийн тусламж тодорхой нөхцөлтэйгээр өгөх, гуравдугаарт: Ар Монголын тусгаар тогнолыг шууд дэмжих нь Орос Хятадын болон бусад гүрнүүдтэй харилцах харилцаанд нь нөлөөлнө гэсэн бодлогын үүднээс маш болгоомжтой хандаж байжээ.